


Малын тооны өөрчлөлт: Үхэр сүрэг


2021 оны байдлаар мал аж ахуйн салбар Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 11.6 хувийг бүрдүүлж, 7.2 их наяд төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна [1]. Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үндсэн нооцүүдийн нэг болох мал сүргийн тоо толгой, байршил, нягтшил түүнд гарч буй өөрчлөлтийн талаарх товч мэдээллийг малын төрөл тус бүрээр цувралаар бэлтгэн хүргэж байна.

Үхэр бол хүн төрөлхтний амжилттай гаршуулсан амьтдын нэг бөгөөд үхрийн сүү, мах, арьс шрийг ашиглахаас гадна газар хагалах зэрэг хүч шаардсан ажилд ашигласаар ирсэн. Иймээс ч үхэр нэн чухал ач холбогдолтой гэрийн тэжээмэл амьтанд тооцогддог болсон төдийгүй эрт үед нэг төрлийн капиталын хэлбэр гэгдэж байжээ [2]. Безон, бантенг, гаял, гаур, буйвал, зербу, сарлаг зэрэг нь үхрийн төрөлд хамаардаг [3]. Дэлхийн хэмжээнд 2012 онд 1001.72 сая, 2015 онд 969.26 сая, 2018 онд 975.06 сая, 2021 онд 937.69 сая, 2023 онд 942.63 сая толгой үхэр байна [4]. Үхрийн тоогоороо Энэтхэг (307.5 сая), Бразил (194.36 сая), Хятад (101.5 сая), АНУ (89.27 сая), Европын Холбоо (74.85 сая), Аргентин (53.12 сая), Австрали (25.8 сая), Мексик (17.85 сая), ОХУ (17.43 сая), Уругвай (11.74 сая) улсууд дэлхийд тэргүүлж байна. 2023 оны байдлаар Энэтхэг, Бразил, Хятад улсуудад дэлхийн нийт үхрийн 64% ноогдож байна [5]. 2022 оны статистик тоо баримтаас үзвэл сүүний чиглэлийн үхрийн тоогоороо Энэтхэг (59.5 сая), Европын Холбоо (20.2 сая), Бразил (16.89 сая), АНУ (9.41 сая), Мексик (6.65 сая), Хятад (6.4), ОХУ (6.4 сая), Шинэ Зеланд (4.87 сая), Их Британи (1.85 сая), Аргентин (1.54 сая) улсууд тэргүүлдэг[4].


Манай улсын үхэрний тоо 2022 онд 5.5 сая толгой байгаа нь 1970 оны дүнгээс 3.4 сая толгойгоор нэмэгдсэн дүн юм. Үхэр сүргийн тоо 1970 онд 2107.83 мянга, 1980 онд 2397.1 мянга, 1990 онд 2848.7 мянга, 2000 онд 3097.6 мянга, 2010 онд 2176 мянга байсан бол 2020 онд 4732.01 мянга болж өсжээ. Үхэр сүргийн тоо толгойн өөрчлөлтийн графикаас (Зураг 1) үзвэл үхрийн тоо жилд дунджаар 1970-1999 онд 47407 толгойгоор ($r^2=0.78$, $p<0.05$), 2003-2009 онд 150189 толгойгоор ($r^2=0.96$, $p<0.05$), 2010-2022 онд 275255 толгойгоор ($r^2=0.97$, $p<0.05$) өссөн байна. 1999-2003 оны ган, зудын нөхцөлтэй холбоотойгоор 1999 онд 3.82 сая толгойд хүрсэн үхэрний тоо 2003 онд 1.79 сая толгой болж 2 сая орчим толгойгоор хоргодсон. 2003-2009 онд үхэрний тоо өссөн ч 2009-2010 оны зудны улмаас 2.59 сая толгойгоос 2.17 сая толгой болж багассан. Сүүлийн 53 жилийн хугацаанд улсын хэмжээнд хамгийн цөөн үхэр тоологдсон жил нь 2003 он (1792.8 мянга) юм. Нийт мал сүрэгт үхэр сүргийн эзлэх хувь 5.8-11.9 хооронд хэлбэлзэж байгаа ба 1970 онд 9.3%, 1980 онд 10.1%, 1990 онд 11%, 2000 онд 10.2%, 2010 онд 6.6%, 2022 онд 7.8% байна. Үхэр сүргийн тоогоор 1970 онд Уянга (26 мянга), Тариат (22.4 мянга), Хангай (21.1 мянга), Эрдэнэцогт (20.9 мянга), Галуут (19.9 мянга), 1980 онд Уянга (34.1 мянга), Тариалан (28 мянга), Хангай (27 мянга), Тариат (26.8 мянга), Эрдэнэцогт (23.4 мянга), 1990 онд Хангай (31 мянга), Тариат (29.3 мянга), Уянга (27.6 мянга), Эрдэнэцогт (24.9 мянга), Их Уул (2.7 мянга), 2000 онд Уянга (44.6 мянга), Өндөр-Уул (37.8 мянга), Тариат (37.2 мянга), Их тамир (31.7 мянга), Эрдэнэмандал (30 мянга), 2010 онд Өндөр-Улаан (31 мянга), Тариат (29.5 мянга), Чулуут (29.2 мянга), Их тамир (26.7 мянга), Рэнчинлхүмбэ (26.4 мянга), 2020 онд Өндөр-Улаан (66.7 мянга), Их тамир (65.3 мянга), Чулуут (64.7 мянга), Цэнхэр (58.4 мянга), Эрдэнэцогт (57.4 мянга) сумууд улсын хэмжээнд тэргүүлж байна. Манай орон төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэн 1990 оноос өмнө ба хойш сумдын үхэр сүргийн тоо толгойд гарсан өөрчлөлтийн хандлагыг Зураг 2, 3-д үзүүллээ. Үхэр сүргийн нягтшилд 1970-2022 онд гарсан өөрчлөлтийг улсын түвшинд авч үзвэл 100 га газар нутагт ногдох үхэрний тоо 1970 онд 1.34, 1975 онд 1.55, 1980 онд 1.53, 1985 онд 1.54, 1990 онд 1.82, 1995 онд 2.12, 2000 онд 1.98, 2005 онд 1.52, 2010 онд 1.39, 2015 онд 2.41, 2022 онд 3.52 болж нэмэгджээ. Сүүлийн 53 жилийн хугацаанд үхэр сүргийн нягтшилд гарсан өөрчлөлтийг сумын түвшинд тодорхойлсон үр дүнг Зураг 4-д үзүүлсэн.



Зураг 1. Үхэр сүргийн тооны өөрчлөлт (1970 - 2022 он)




Зураг 2. Үхэр сүргийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага (1970 - 1990 он)



Зураг 3. Үхэр сүргийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага (1991 - 2022 он)

Ашигласан материал

1. Үндэсний статистикийн хороо. (2022). Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга 2021. Улаанбаатар, Монгол. https://www2.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Agriculture_2021.pdf&ln=Mn (2000).
2. Felius, M., Beerling, M.-L., Buchanan, D., Theunissen, B., Koolmees, P., Lenstra, J.: On the History of Cattle Genetic Resources. Diversity. 6, 705–750 (2014). <https://doi.org/10.3390/d6040705>.
3. Төмөржав, М., Энхтүвшин, Б., Санбилдэндэв, Х., Эрдэнэцогт, Н., Очир, А., Цэвэндорж, Д., Эрдэнэболд, Л., Баярсайхан, Баатархүү, Цэрэндорж, Баясгалан, Т.: “Нүүдлийн мал аж ахуйн түүх” сэдэвт төслийн эрдэм шинжилгээний тайлан. Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн, Улаанбаатар, Монгол (2008).
4. statista: Number of cattle worldwide from 2012 to 2023, <https://www.statista.com/statistics/263979/global-cattle-population-since-1990/>, last accessed 2023/10/05.
5. Beef2Live: Ranking Of Countries With The Most Cattle, <https://beef2live.com/story-world-cattle-inventory-countries-0-106905>, last accessed 2023/10/08.
6. Үндэсний статистикийн хороо: Малын тоо, https://www2.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSQ_1001_021V1



Зураг 5. Үхэр сүргийн нягтшилд гарсан өөрчлөлт (1970 - 2022 он)